



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх ажлын хүрээнд “Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 2.1, 2.2, 2.4, 2.6, 2.7 дахь заалтуудад заасан эрх үүргийг “Монголын авто замчдын холбоо” ТББ-д шилжүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу холбогдох материалыг хүлээн авч дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах, тусгай зөвшөөрөлтэй холбоотой цахим мэдээллийн сан бүрдүүлэх, баяжилт хийх ажлыг зохион байгуулж ажиллахыг “Монголын авто замчдын холбоо” ТББ /Т.Бямбаа/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 65 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Э.Энхбат/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



Ж.БАТ-ЭРДЭНЭ

080424